



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 30

№ 04/21

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ ТАНАА

Иргэн "...Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв нь 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан Үндсэн мэргэшлийн сургалтын 2022-2023 оны элсэлтийн шалгалт өгсөн эмч, мэргэжилтнүүдийн дүнг цахим хуудсаар мэдээлэхдээ овог нэрийг бүтнээр ил тавьсан нь доогуур үнэлгээ авсан зарим хүмүүс удирдах албан тушаалтнаас зэмлэл хүлээх, бусад хүмүүсээс ичиж, эвгүйцэх байдал хүргэсэн" гэх гомдлыг Комисст гаргажээ.

Гомдлын дагуу гомдол гаргагчаас тодруулга, холбогдох албан тушаалтнаас тайлбар авч, баримт, нөхцөл байдлыг хянаж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна.

1. Эрүүл Мэндийн хөгжлийн төвөөс Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/337 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 15.4.12 дахь хэсэгт "Элсэлтийн шалгалтын комиссоос хүлээлгэн өгсөн элсэлтийн шалгалтын дүнг мэргэжилтэн болон олон нийтэд элсэлтийн шалгалт авсны дараахь өдрийн 12 цагт багтаан үнэн зөв мэдээлэх" гэж заасны дагуу шалгалтын дүнг <http://www.hdc.gov.mn/> цахим хуудаст мэдээлэхдээ шалгалтанд орсон мэргэжилтнүүдийн эцэг, эхийн болон өөрийн нэрийг нийтэд ил байршуулсан байна.
2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн <http://www.hdc.gov.mn/> цахим хуудаст байршуулсан бусад тогтоол, шийдвэр, мэдээллийг санамсаргүй байдлаар түүвэрлэн үзэхэд эмч, мэргэжилтнүүдийн нэр, регистрын дугаар, лицензийн дугаар, гэрийн болон оршин суугаа хаяг, албан байгууллагын талаарх хувийн мэдээллийг ил байршуулсан нь түгээмэл байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт "...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд "Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно" гэж хувийн нууц, хувийн мэдээллээ хамгаалуулах эрхийг баталгаажуулжээ.

Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах зарчим, мэдээлэл хариуцагч байгууллагын үүргийг тодорхойлжээ. Тухайлбал, мэдээлэл хариуцагч хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах үүрэгтэй.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх хэсэгт хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээлэл зэрэг хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хүний хувийн мэдээлэлд тооцохоор заасан байна.

Монгол Улсын Эрүүл Мэнд, Спортын Сайдын 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 98 дугаар тушаалаар баталсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 5.6 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хүний хувийн мэдээллийг нийтэд ил тод тавих нь хүний эрхийн зөрчил болох юм.

Иргэн [ ] болон бусад эмч, мэргэжилтнүүдийн мэдээллийг цахим хуудаст нээлттэй байршуулсан нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчсөн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөний зөрчлийг таслан зогсоох, цаашид зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авахыг шаардаж байна. Үүнд:

1. Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн (<http://www.hdc.gov.mn>) цахим хуудсанд байршсан Үндсэн мэргэшлийн сургалтын 2022-2023 оны элсэлтийн шалгалтын нэгдсэн дүнг хүний хувийн мэдээллийг хамгаалах шаардлагад нийцсэн байдлаар засаж байршуулах, ийм боломжгүй тохиолдолд мэдээллийг устгах.

2. Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн цахим хуудаст байршсан, тухайн зар, мэдээллийн зорилгод шаардлагатайгаас илүү хэмжээнд хүний хувийн мэдээллийг ил болгосон бусад зарлал, дүн, мэдээллийг дээрх шаардлагын дагуу өөрчлөх, ийм боломжгүй тохиолдолд зөрчил бүхий мэдээллийг устгах.

3. Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/337 дугаар тушаалаар баталсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүнчингүй болгох журам" болон бусад холбогдох ижил зөрчил агуулсан журмуудыг нэн даруй "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" хуульд нийцүүлэн шинэчлэн батлах.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Комиссын гишүүн шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж заасан.

Шаардлагын мөрөөр авсан арга хэмжээний танилцуулгыг, баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлнэ үү. Энэ шаардлагын 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг анхааруулж байна. Шаардлагад тусгагдсан бусад асуудлын талаар танай байгууллагаас Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсээс тусгайлсан зөвлөгөө хүсэх боломжтой.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж заасан.

ГИШҮҮН



Г.НАРАНТУЯА